

БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Булган сумын ерөнхий боловсролын 2 дугаар сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: БӨА-2023/47/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: [www.audit.mn](http://www.audit.mn)  
Өлгий хот  
2023 он

Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,  
тэргүүлэх аудитор: М.Хуанган  
Утас: 70422954 Цахим хаяг: khuanganm@audit.gov.mn  
Аудитын менежер: Х.Женисбек  
Утас: 70422930 Цахим хаяг: jenisbekh@audit.gov.mn  
“Анализ старт Аудит” ХХК-ны захирал: Н.Энхтуяа  
Утас: 99075818 Цахим хаяг: [asaudit.mn@gmail.com](mailto:asaudit.mn@gmail.com)  
Аудитор: Н.Энхтуяа  
Утас: 99075818 Цахим хаяг: asaudit.mn@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу. .

АГУУЛГА

---

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ.....	2
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ.....	4
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА .....	10
4. АУДИТЫН ТАЙЛАН .....	13
4.1 Ерөнхий зүйл.....	13
4.2 Материаллаг байдал .....	14
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт .....	14
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	14
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт .....	14
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	15
4.5.1 Завсрын аудитын талаар.....	
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	15
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ .....	15
5.1 Төлбөрийн акт .....	15
5.2 Албан шаардлага.....	15
5.3 Зөвлөмж .....	15
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ .....	

**Товчилсон үгийн жагсаалт**

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын стандарт

# 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



## БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

83129 Өлгий, Баян-Өлгий аймаг,  
Утас/Факс: (976) 7042-2954  
E-mail: bayanulgii@audit.gov.mn

БУЛГАН СУМЫН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН  
2 ДУГААР СУРГУУЛИЙН ЗАХИРАЛЫН  
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ  
М.КҮЛШАШ ТАНАА

2023.02.17 № 78  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_ -Т

### Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Булган сумын ерөнхий боловсролын 2 дугаар сургуулийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Булган сумын ерөнхий боловсролын 2 дугаар сургуулийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

### Асуудлыг онцолсон хэсэг

Сургуулийн 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайлантай холбоотой онцлох асуудал гараагүй.

### Аудитын гол асуудал

Хүнсний материалын бүртгэл, тооллого, тооцоонд тавих дотоод хяналтыг сайжруулах шаардлагатай.

### Бусад асуудлын хэсэг

Аудит, аудиторын хариуцлага, аудитын тайлангийн тухай хэрэглэгчдэд хамаатай бөгөөд санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй.

### Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  М.ХУАНГАН



## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Төгрөгөөр

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>41,125,729.19</u></b>	<b><u>94,786,871.19</u></b>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	-	16,537,671.00
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	-	16,537,671.00
3121	Төгрөг	-	16,537,671.00
31211	Төрийн сангийн харилцах		16,527,671.00
31215	Нэмэлт санхүүжилтийн харилцах	-	10,000.00
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	<b>41,035,295.19</b>	<b>78,249,200.19</b>
351	Түүхий эд материал	500,000.00	500,000.00
35110	Тусгай зориулалттай материал	500,000.00	500,000.00
354	Хангамжийн материал	39,713,295.19	76,927,200.19
35410	Бичиг хэргийн материал	1,020,900.00	1,020,900.00
35420	Аж ахуйн материал	22,301,003.50	27,640,000.50
35440	Түлш, шатах тослох материал	5,412,420.10	27,368,660.10
35460	Хүнсний материал	10,242,471.59	20,161,139.59
35470	Бусад хангамжийн материал	736,500.00	736,500.00
35600	Мал амьтад	822,000.00	822,000.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>2,255,696,909.22</u></b>	<b><u>2,210,179,120.94</u></b>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	2,255,696,909.22	2,210,179,120.94
392	Биет хөрөнгө	2,213,794,909.22	2,168,277,120.94
39201	Барилга, байгууламж, орон сууц	2,284,674,912.24	2,284,674,912.24
39202	Хуримтлагдсан элэгдэл	(112,201,542.57)	(155,575,566.09)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	45,244,354.00	52,739,354.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(27,786,220.40)	(33,021,191.00)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	36,658,409.41	36,658,409.41
39208	Хуримтлагдсан элэгдэл	(15,432,203.46)	(19,835,997.62)
39217	Ном	2,637,200.00	2,637,200.00
393	Биет бус хөрөнгө	41,902,000.00	41,902,000.00
39301	Програм хангамж	550,000.00	550,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(550,000.00)	(550,000.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	41,902,000.00	41,902,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b><u>2,296,822,638.41</u></b>	<b><u>2,304,965,992.13</u></b>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	=	<b><u>209,310.00</u></b>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	-	209,310.00
413	Өглөг	-	209,310.00
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	-	209,310.00
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b><u>2,296,822,638.41</u></b>	<b><u>2,304,756,682.13</u></b>
51	Засгийн газрын хувь оролцоо	2,296,822,638.41	2,304,756,682.13
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	135,116,466.00	135,116,466.00
51101	Өмч: - төрийн	135,116,466.00	135,116,466.00

Булган сумын ерөнхий боловсролын 2 дугаар сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

512	Хуримтлагдсан үр дүн	1,965,777,107.37	1,973,711,151.09
51210	Өмнөх үеийн үр дүн	1,965,777,107.37	1,965,777,107.37
51220	Тайлант үеийн үр дүн	-	7,934,043.72
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	195,929,065.04	195,929,065.04
6	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b><u>2,296,822,638.41</u></b>	<b><u>2,304,965,992.13</u></b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Төгрөгөөр

ДАНС	ҮЗҮҮЛЭЛТ	ҮЛДЭГДЭЛ	ГҮЙЦЭТГЭЛ
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	315,781,056.41	420,381,100.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	4,204,840.00	-
120	Нийтлэг татварын бус орлого	4,204,840.00	-
120004	Төсөвт байгууллагын өөрийн орлого	4,204,840.00	-
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	4,204,840.00	-
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	46,679,516.41	420,381,100.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	15,057,824.41	336,728,800.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	-	336,728,800.00
131005	Хөрөнгийн санхүүжилт	15,057,824.41	-
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	264,896,700.00	-
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	15,357,692.00	2,700,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчаас төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захи	10,473,822.00	-
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	4,883,870.00	2,700,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	16,264,000.00	80,952,300.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	16,264,000.00	80,952,300.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН (II)	360,399,873.17	412,447,056.28
21	УРСГАЛ ЗАРДАЛ	360,399,873.17	412,447,056.28
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	351,043,451.17	403,876,412.28
2101	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	214,035,107.00	258,054,360.00
210101	Цалин	185,288,607.00	202,633,244.00
210102	Нэмэгдэл цалин	-	45,170,982.00
210104	Урамшуулал	10,595,300.00	10,250,134.00
210105	Гэрээтийн цалин	18,151,200.00	-
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	27,683,319.00	32,314,850.00
210201	Тэтгэврийн даатгалын шимтгэл	18,223,184.00	22,679,750.00
210202	Тэтгэмжийн даатгалын шимтгэл	2,364,488.00	2,646,600.00
210203	ҮОМШ өвчний даатгалын шимтгэл	1,892,903.00	2,043,200.00
210204	Ажилгүйдлийн даатгалын шимтгэл	473,769.00	449,300.00
210205	Эрүүл мэндийн даатгалын хураамж	4,728,975.00	4,496,000.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	23,426,588.90	27,532,760.00

210301	Гэрэл цахилгааны зардал	1,877,100.00	4,000.00
210302	Түлш, халаалтын зардал	21,549,488.90	27,528,760.00
2104	Хангамж, бараа материалын зардал	16,836,116.00	3,146,623.00
210401	Бичиг хэргийн материал	1,820,520.00	166,500.00
210402	Тээвэр, шатахууны зардал	4,725,000.00	2,588,620.00
210403	Шуудан холбоо интернетийн төлбөр	408,300.00	-
210406	Бага үнэ түргэн элэгдэл зүйлс	2,040,287.00	391,503.00
210408	Бараа материал актасны зардал	7,842,009.00	-
2105	Нормативт зардал	15,294,839.50	23,100,831.00
210501	Эм	384,600.00	-
210502	Хоол	13,925,739.50	23,100,831.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	984,500.00	-
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	364,400.00	-
210604	Урсгал засвар	364,400.00	-
2107	Томилолт, зочны зардал	150,900.00	-
210702	Дотоод томилолтын зардал	150,900.00	-
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамж	420,200.00	1,511,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	20,200.00	-
210802	Аудит, баталгаажуулалт зэрэглэл тогтоох зардал	400,000.00	-
210806	Мэдээллийн технологийн үйлчилгээний хөлс	-	1,511,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	52,831,980.77	58,215,988.28
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	3,390,200.00
210902	Хичээл сургалт, үйлдвэрлэлийн дадлагын зардал	453,100.00	1,813,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	52,378,880.77	53,012,788.28
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	9,356,422.00	8,570,644.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	9,342,600.00	7,470,744.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	9,342,600.00	7,470,744.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	13,822.00	-
261090	Төвлөрүүлэх шилжүүлэг	13,822.00	-
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	-	1,099,900.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	1,099,900.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III=I-II)	(44,618,816.76)	7,934,043.72
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН (V)	5,084,061.99	-
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	5,084,061.99	-
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (VI=IV-V)	(5,084,061.99)	-
5	НИЙТ ҮР ДҮН (VII=III+VI)	(49,702,878.75)	7,934,043.72

### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Төгрөгөөр

Булган сумын ерөнхий боловсролын 2 дугаар сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b><u>296,518,392.00</u></b>	<b><u>420,381,100.00</u></b>
<b>11</b>	<b>ТАТВАРЫН ОРЛОГО</b>	-	<b>336,728,800.00</b>
<b>113</b>	<b>Хөрөнгийн албан татвар</b>	-	336,728,800.00
<b>113001</b>	Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар	-	336,728,800.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>296,518,392.00</b>	<b>83,652,300.00</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	15,357,692.00	2,700,000.00
<b>131105</b>	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	4,883,870.00	2,700,000.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	16,264,000.00	80,952,300.00
<b>132001</b>	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	16,264,000.00	80,952,300.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b><u>292,045,392.00</u></b>	<b><u>396,348,429.00</u></b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>292,045,392.00</b>	<b>396,348,429.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>282,161,570.00</b>	<b>375,362,694.00</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	208,497,500.00	258,054,360.00
<b>210101</b>	Үндсэн цалин	179,751,000.00	202,633,244.00
<b>210102</b>	Нэмэгдэл	-	45,170,982.00
<b>210104</b>	Урамшуулал	10,595,300.00	10,250,134.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	28,147,200.00	32,224,416.00
<b>210201</b>	Тэтгэврийн даатгал	19,807,300.00	22,589,316.00
<b>210202</b>	Тэтгэмжийн даатгал	2,085,100.00	2,646,600.00
<b>210203</b>	ҮОМШӨ-ний даатгал	1,667,900.00	2,043,200.00
<b>210204</b>	Ажилгүйдлийн даатгал	417,000.00	449,300.00
<b>210205</b>	Эрүүл мэндийн даатгал	4,169,900.00	4,496,000.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	24,364,000.00	49,575,000.00
<b>210301</b>	Гэрэл, цахилгаан	1,093,000.00	1,590,000.00
<b>210302</b>	Түлш, халаалт	23,271,000.00	47,985,000.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	8,696,470.00	1,700,000.00
<b>210402</b>	Тээвэр, шатахуун	4,725,000.00	1,700,000.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	7,582,200.00	20,591,248.00
<b>210502</b>	Хоол, хүнс	6,733,700.00	20,591,248.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	300,000.00	347,000.00
<b>210604</b>	Урсгал засвар	300,000.00	347,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	588,700.00	1,511,000.00
<b>210806</b>	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	-	1,511,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	3,834,600.00	11,359,670.00
<b>210901</b>	Бараа үйлчилгээний бусад зардал	-	8,965,200.00
<b>210902</b>	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,834,600.00	2,394,470.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>9,883,822.00</b>	<b>20,985,735.00</b>

2132	Бусад урсгал шилжүүлэг	9,870,000.00	19,885,835.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	9,870,000.00	19,885,835.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	13,822.00	1,099,900.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	13,822.00	1,099,900.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>4,473,000.00</u>	<u>24,032,671.00</u>
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	4,473,000.00	7,495,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	4,473,000.00	7,495,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	4,473,000.00	7,495,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	4,473,000.00	7,495,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>(4,473,000.00)</u>	<u>(7,495,000.00)</u>
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-	16,537,671.00

#### 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Төгрөгөөр

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	135,116,466.00	196,962,265.04	2,014,446,786.12	2,346,525,517.16
C07	Тайлант үеийн үр дүн			-49,702,878.75	-49,702,878.75
C08	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	135,116,466.00	196,962,265.04	1,964,743,907.37	2,296,822,638.41
D01	2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	135,116,466.00	196,962,265.04	1,964,743,907.37	2,296,822,638.41
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				0.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	135,116,466.00	196,962,265.04	1,964,743,907.37	2,296,822,638.41
D08	Тайлант үеийн үр дүн			7,934,043.72	7,934,043.72
D09	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	135,116,466.00	196,962,265.04	1,972,677,951.09	2,304,756,682.13

#### 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Төгрөгөөр

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	417,680,870.00	402,743,529.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	417,680,870.00	402,743,529.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	397,427,770.00	382,857,694.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	272,642,100.00	258,054,360.00
210101	Үндсэн цалин	215,723,200.00	202,633,244.00

Булган сумын ерөнхий боловсролын 2 дугаар сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210102	Нэмэгдэл	46,046,200.00	45,170,982.00
210104	Урамшуулал	10,872,700.00	10,250,134.00
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	33,629,200.00	32,224,416.00
210201	Тэтгэврийн даатгал	22,867,700.00	22,589,316.00
210202	Тэтгэмжийн даатгал	2,690,400.00	2,646,600.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,152,300.00	2,043,200.00
210204	Ажилгүйдлийн даатгал	538,100.00	449,300.00
210205	Эрүүл мэндийн даатгал	5,380,700.00	4,496,000.00
2103	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	49,593,000.00	49,575,000.00
210301	Гэрэл, цахилгаан	1,593,000.00	1,590,000.00
210302	Түлш, халаалт	48,000,000.00	47,985,000.00
2104	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	-	1,700,000.00
210402	Тээвэр, шатахуун		1,700,000.00
2105	<b>Нормативт зардал</b>	21,834,100.00	20,591,248.00
210502	Хоол, хүнс	21,834,100.00	20,591,248.00
2106	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	350,000.00	347,000.00
210604	Урсгал засвар	350,000.00	347,000.00
2108	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	1,511,800.00	1,511,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,511,800.00	1,511,000.00
2109	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	17,867,570.00	18,854,670.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	15,473,100.00	16,460,200.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,394,470.00	2,394,470.00
213	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	20,253,100.00	19,885,835.00
2132	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	20,253,100.00	19,885,835.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	20,253,100.00	19,885,835.00
13	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	417,681,100.00	416,581,200.00
1310	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	336,728,800.00	336,728,800.00
131001	Улсын төсвөөс санхүүжих	336,728,800.00	336,728,800.00
1320	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	80,952,300.00	79,852,400.00
132001	Орон нутгийн төсвөөс	80,952,300.00	79,852,400.00

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан Нэмэлт төсөв 2 700.0 мянган төгрөг авсан байна.

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
I	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>2,690,000.00</b>
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>2,690,000.00</b>
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	2,690,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	1,700,000.00
210402	Тээвэр, шатахуун	1,700,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	990,000.00

210901	Бараа үйлчилгээний бусад зардал	990,000.00
II	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	2,700,000.00
1311	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	2,700,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	2,700,000.00

### 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

#### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

##### *Байгууллагын үйл ажиллагааны чиглэл, зорилго, зорилтын талаар*

Булган сумын ерөнхий боловсролын хоёрдугаар сургууль нь боловсрол олгох чиг үүрэгтэй байгууллага. Тус сургууль нь 2022 онд “Суралцагчийн сурлагын хоцрогдлыг нөхөж, бие даан сурах үйлийг дэмжихэд бүх талын оролцоог ханган, сургалтын үйл ажиллагааг үр дүнтэй зохион байгуулах” зорилго дэвшүүлэн ажилласан байна.

Дээрх зорилгыг биелүүлэхээр дараах зорилтыг дэвшүүлэн ажилласан байна. Үүнд:

- Багш ээлжит хичээлийн бэлтгэлийг сургалтын хэлбэрээс үл хамааран чанартай бэлтгэж үр дүнтэй хэрэгжүүлэх
- Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох сургалтыг үр дүнтэй зохион байгуулж, элсэлтийн ерөнхий шалгалтын үр дүнг ахиулах
- Даалгаварт суурилсан арга зүйг боловсруулж, сургалтын чанарт ахиц гаргах.
- Багш, ажилчид, сурагчдыг стрессээс сэргийлэх, айдас түгшүүр, сэтгэл зовнилгүй ажиллах, суралцахад сэтгэл зүйн дэмжлэг үзүүлэх, ажлын байранд эерэг уур амьсгал бүхий байгууллагын соёлыг бүрдүүлэх
- Хүүхэд хамгааллын үйл ажиллагааны хэрэгжүүлэх, хүүхдийн бүх талын хөгжлийг дэмжин оролцоог хангаж, сургууль завсардахаас сэргийлэн, эцэг эх олон нийттэй хамтран ажиллах.
- Монгол хэл бичгийн чадварыг сайжруулах цогц үйл ажиллагааг хэрэгжүүлэх, түгээн дэлгэрүүлэх.
- "Монгол бичгийн үндэсний хөтөлбөр-3"-ын хүрээнд сургуулийн мэргэжлийн бүлгийг байгуулж, үйл ажиллагааны төлөвлөгөөг батлан хэрэгжүүлэх.
- Сурагчдыг тэгш хамааруулан сургах үйлийг дэмжих дэмжлэгийн багийн үйл ажиллагааны төлөвлөгөөг батлан хэрэгжүүлэх

#### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

##### *Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй хууль эрх зүйн орчны талаар*

Булган сумын ерөнхий боловсролын хоёрдугаар сургууль нь Боловсролын тухай хууль, Бага, дунд боловсролын тухай хууль болон бусад боловсролын байгууллагуудад мөрдөж байгаа хууль тогтоомжуудыг үйл ажиллагаандаа мөрдөж ажилласан байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна.

Улсын Их Хурлаас Төсвийн тухай хуульд 2022 оны 4 дүгээр сарын 22-ны өдрийн хуулиар оруулсан өөрчлөлтөөр боловсролын салбарын байгууллагууд улсын төсвөөс санхүүжиж, БСШУС-ын харьяа Боловсролын ерөнхий газарт санхүүгийн тайлангаа нэгтгэлд тушаадаг болсон байна.

Булган сумын ерөнхий боловсролын 2 дугаар сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тухайлбал: Байгууллагаас гарч байгаа тушаал шийдвэр болон байгууллагын даргын тушаал шийдвэрийн хэрэгжилт, хуулийн үндэслэл бусад байгууллага, иргэдээс ирүүлсэн албан бичиг, өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн байдал, байгууллагын дотоод ажлын зохион байгуулалт хөдөлмөрийн сахилга, ажлын цаг ашиглалт, байгууллагын ажлын төлөвлөгөөний биелэлт, дээд байгууллагын тогтоол шийдвэрийн биелэлт, байгууллагын удирдлагаас өгсөн үүрэг даалгаврын хэрэгжилт зэрэг ажил хамрагдаж байна.

Аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, аудитын алба нь тус аймгийн төсөвт байгууллагуудын санхүү, бүртгэлийн үйл ажиллагаанд хяналт тавих чиг үүрэг бүхий байгууллага юм. Булган сумын ерөнхий боловсролын хоёрдугаар сургууль 2022 онд шалгалтад хамрагдаагүй тул дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

### **3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Булган сумын ерөнхий боловсролын хоёрдугаар сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

### ***Байгууллагын мөрдөж буй нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн талаар***

Булган сумын ерөнхий боловсролын хоёрдугаар сургуулийн захирлын 2020 оны 01 дугаар сарын 13-ны өдрийн 06 тоот тушаалаар баталсан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг ашигладаг байна.

### **3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд**

Булган сумын ерөнхий боловсролын хоёрдугаар сургуулийн 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 8.1 сая төгрөгөөр буюу 0.35 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	16.537.7	16.537.7
Авлага	90.4	-	-90.4
Бараа материал	41.035.3	78.249.2	37.213.9
Үндсэн хөрөнгө	2.255.696.9	2.210.179.1	-45.517.8
Нийт хөрөнгө	2.296.822.6	2.304.966.0	<b>8.143.3</b>
Өр төлбөр		209.3	209.3
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	2.296.822.6	2.304.756.7	7.934.0
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн ДҮН	<b>2.296.822.6</b>	<b>2.304.966.0</b>	<b>8.143.3</b>

Мөнгөн хөрөнгө, авлага, бараа материал, үндсэн хөрөнгө, өр төлбөр дансанд өмнөх оны үзүүлэлтээс нөлөө бүхий өөрчлөлт гарсан байна.

Мөнгөн хөрөнгийн данс оны эцэст 16.5 сая төгрөгийн үлдэгдэлтэй гарсан нь батлагдсан төсвөөс цалингийн зардал, ажил олгогчийн шимтгэлийн зардал, нормативт зардал, урсгал шилжүүлэгийн зардлын хэмнэлт байна. Цалингийн хэмнэлт 14.6 сая төгрөг буюу нийт хэмнэлтийн 88.5 хувийг, ажил олгогчийн шимтгэлийн зардлын хэмнэлт 1.4 сая төгрөг буюу нийт хэмнэлтийн 8.5 хувийг, нормативт зардлын хэмнэлт 1.2 сая, бараа ажил үйлчилгээний зардлын хэтрэлт 0,9 сая төгрөг, урсгал шилжүүлгийн зардал 0.3 сая төгрөг буюу нийт хэмнэлтийн 0.4 хувийг тус тус эзэлж байна.

Авлагын дансны оны эхний үлдэгдлийг барагдуулсан байна.

Үндсэн хөрөнгийн данс 45.5 сая төгрөгөөр буурсан нь 7.5 сая төгрөгийн хөрөнгийг орлого авч, үндсэн хөрөнгөнд тайлант онд 53.0 сая төгрөгийн элэгдэл байгуулсантай холбоотой байна.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй гэсний дагуу тус сургууль нь 2022-2023 оны төсвийн хүрээний мэдэгдлийг зохих журмын дагуу боловсруулан дээд шатны удирдлагад өгч батлуулсан байна.

#### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 379.3 сая, орон нутгийн төсвөөс 80.9 сая, нийт зарлагыг 460.2 сая төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Дээд шатны төсвийн захирагчаас төсвийг хянаж Төсвийн төслийн саналаас зардлыг 42.5 сая төгрөгөөр бууруулж 417.7 сая төгрөгөөр баталсан байна.

#### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны батлагдсан төсвийн хуваарьт өөрчлөлт оруулсан байна. Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 10 арга хэмжээг санхүүжүүлэхээр 336.7 сая төгрөгийг улсын төсвөөс, 80.9 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс бүрдүүлэхээр тусгасан байна.

Булган сумын ерөнхий боловсролын 2 дугаар сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 416.6 сая төгрөгийн, орон нутгийн төсвөөс 79.8 сая төгрөгийн санхүүжилт олгосон байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 402.7 сая төгрөг буюу 96.4 хувьтай байгаа нь үндсэн цалингийн зардлын төсвийг 13.0 сая төгрөгөөр, нэмэгдэл цалингийн төсвийг 0.9 сая төгрөгөөр, нэмэгдэл цалингийн зардлыг 0.6 сая төгрөгөөр, ажил олгогчийн шимтгэлийн зардлын төсвийг 1.4 сая төгрөгөөр, нормативт зардлыг 1.2 сая төгрөгөөр хэмнэж, бараа үйлчилгээний бусад зардлыг 0.9 сая төгрөгөөр илүү зарцуулан, урсгал шилжүүлгийн зардлыг 0,3 дутуу зарцуулсантай холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	Эрүүл мэндийн арга хэмжээ	684,200.00	684,200.00	-	100.00%
2	Боловсролын стандарт, сургалты	183,568,300.00	181,907,912.00	1,660,388.00	99.10%
3	Үдийн цай хөтөлбөр	20,253,100.00	19,885,835.00	367,265.00	98.19%
4	Хүүхдэд ээлтэй сургалтын орчин	7,495,000.00	7,495,000.00	-	100.00%
5	Боловсролын байгууллагын багш ажилчдын мэргэжил дээшлүүлэх	1,379,400.00	1,378,500.00	900.00	100.00%
6	Сургалтын хэвийн үйл ажиллагааг хангах	84,745,100.00	73,128,734.00	11,616,366.00	86.29%
7	Сургалт семинар	216,500.00	216,500.00	-	100.00%
8	Байр ашиглалтын үйлчилгээ	433,000.00	433,000.00	-	100.00%
9	Дотуур байрны үйлчилгээ	37,954,200.00	36,661,548.00	1,292,652.00	96.59%
10	Нийтлэг үйлчилгээ	80,952,300.00	80,952,300.00	-	100.00%
	дүн	417,681,100.00	402,743,529.00	14,937,571.00	96.42%

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Булган сумын ерөнхий боловсролын хоёрдугаар сургууль 2022 онд 2.7 сая төгрөгийн нэмэлт төсөв авч зарцуулсан байна.

### 3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Булган сумын ерөнхий боловсролын хоёрдугаар сургууль 2022 онд төсөл хөтөлбөр хэрэгжүүлээгүй байна.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу

БӨА-2023/47/НА-СТА-ТШЗ

Булган сумын ерөнхий боловсролын хоёрдугаар сургуулийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах хууль тогтоомжийн хэрэгжилт, бүртгэл тайлагналтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Улаанбаатар хотын “Анализ старт аудит” ХХК-ны аудитор Н.Энхтуяа гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Х.Женисбек, дарга, тэргүүлэх аудитор М.Хуанган нар тус тус хэрэгжүүлсэн.

Булган сумын ерөнхий боловсролын хоёрдугаар сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн 01 дугаартай албан бичгээр ирүүлсэн байна.

#### **4.2 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг Булган сумын ерөнхий боловсролын хоёрдугаар сургуулийн 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 360.4 сая төгрөгөөс 1.5 хувиар буюу 5.4 сая төгрөгөөр, тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

#### **4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ажилласан байна. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг шалгахад алдаа, зөрчил илрээгүй. Нүүрсийг их хэмжээгээр нөөцөлсөн

#### **4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

##### **4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант онд Шилэн дансны мэдээллээс шалгах программд орсон мэдээллүүдийн хэрэгжилтийг шалгав. Шилэн дансанд мэдээлсэн байдлын хэрэгжилтийн хувь 100.0% байна.

#### 4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Бусад хууль тогтоомжийн хүрээнд алдаа, зөрчилтэй асуудал гараагүй болно.

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд хийсэн аудитаар нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

#### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Булган сумын ерөнхий боловсролын хоёрдугаар сургуульд завсрын аудит хийгдээгүй байна. Өмнөх оны аудитаар 5.4 сая төгрөгийн 1 зөвлөмж, 8.7 сая төгрөгийн 2 албан шаардлага өгөгдсөнийг хэрэгжүүлсэн байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/ төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт					
Албан шаардлага	2	8.700.0	2	8.700.0	100%
Зөвлөмж	1	5.400.0	1	5.400.0	100%
<b>Нийт дүн</b>	<b>3</b>	<b>14.100.0</b>	<b>3</b>	<b>14.100.0</b>	<b>100%</b>

#### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Цаг хугацааны хязгаарлагдмал байдлаас шалтгаалан санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн зарцуулалтыг түүвэрлэн шалгасан тул гүйцэтгэлийн аудитаар дэлгэрэнгүй шалгах шаардлагатай байна.

### 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар санхүүгийн тайланд залруулга хийгдээгүй.

Аудитаар хүнс болон түлшний материалын бүртгэл тооцоо, тайлагналтай холбоотой илэрсэн зөрчилд 2 зөвлөмж өгөгдлөө.

#### 5.1 Төлбөрийн акт

Төлбөрийн акт тогтоогдоогүй.

#### 5.2 Албан шаардлага

Албан шаардлага өгөгдөөгүй.

#### 5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

#### 1. Хүнсний материалын бүртгэл тооцоо, тооллоготой холбоотой асуудал

##### 1.1.Илрүүлэлт:

Хүнсний материал оны эхэнд 10.2 сая, оны эцэст 20.1 сая төгрөгийн үлдэгдэлтэй байгаа /өмнөх оны хүнсний материалын үлдэгдлээс 0.4 сая төгрөгийн хүнсний материалыг зарлагын гүйлгээ гараагүй/ бөгөөд жилийн эцсийн үлдэгдлийн тооллого, тооцоог зохих журмаар хийж баталгаажуулаагүй байна.

#### 1.2. Өгсөн зөвлөмж:

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах” гэсэн заалтыг баримталж хүнсний материалыг хэрэгцээнд тулгуурлан худалдан авалт хийж, хадгалалт хамгаалалтыг сайжруулах, чанар байдлаа алдагдахаас урьдчилан сэргийлэх, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2-т заасны дагуу хүнсний бараа материалын үлдэгдлийн тооллого, тооцоог бодитой хийж үлдэгдлийг баталгаажуулж ажиллах.

### **2. Нүүрсний үлдэгдэл болон тооллоготой холбоотой асуудал**

#### 2.1.Илрүүлэлт:

Түлшний материалд оны эцэст 27.3 сая төгрөгийн нүүрсний үлдэгдэлд байгаа нь бүтэн жилийн хэрэгцээний нүүрсийг нөөцөлж авсан тооцоо гарч байгаа нь их хэмжээгээр нөөцөлсөн гэж үзэх үндэслэлтэй байгаа ба жилийн эцсийн үлдэгдлийн тооллого, тооцоог зохих журмаар хийж баталгаажуулаагүй байна.

#### 2.2. Өгсөн зөвлөмж:

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах” гэсэн заалтыг баримталж нүүрсийг хэрэгцээнд тулгуурлан худалдан авалт хийх, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2-т заасныг дагуу нүүрсний материалын үлдэгдлийн тооллогыг бодитой хийж үлдэгдлийг баталгаажуулж ажиллах.

### **3. Үйлчилгээний албан хаагчдын ур чадвартай холбоотой асуудал**

3.1.Илрүүлэлт: Сургуулийн үйлчилгээний албан хаагчдын ур чадварыг үнэлж дүгнэх ажил хийгдээгүй байна.

#### 3.2. Өгсөн зөвлөмж:

Хүн амын бодлого, хөдөлмөрийн сайд, Сангийн сайдын 1996 оны 63/104 тоот хамтарсан тушаалаар баталсан “Төрийн үйлчилгээний албаны түгээмэл мэргэжлийн албан хаагчдад ур чадварын нэмэгдэл олгох журам”-ыг баримталж үйлчилгээний албан хаагчдын ур чадварыг үнэлж дүгнэх, шалгуур хангасан албан хаагчдад ур чадварын нэмэгдэл олгох асуудлыг төсвийн хүрээнд шийдвэрлэж байх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2023 оны 10 дугаар сарын 05-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

### **6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ**

Булган сумын ерөнхий боловсролын 2 дугаар сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Дүн												

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Үүнээс				Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
							Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Хүнсний материалын тооллого тооцоог дохих журмаар хийгээгүй	1	20.161.1					1	20.161.1				
Нүүрсний тооллого хийгээгүй, үлдэгдлийг баталгаажуулаагүй байх	1	27.368.7					1	27.368.7				
Дүн	2	47.529.9					2	47.529.9				